



“МОНГОЛЫН АВТО ЗАМЧДЫН  
ХОЛБОО” ТББ-Д

**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251  
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,  
Цахим шуудан: info@mrttd.gov.mn,  
Цахим хуудас: www.mrttd.gov.mn

2024-04-23 № 06/1738  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тушаал мөрдөж ажиллах тухай**

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 256 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм” ЗЗБНБД 81-013-2019-д Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/63 дугаар тушаалаар өөрчлөлт оруулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 4457 дугаарт 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр бүртгэж хүчин төгөлдөр болсон.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т “Захиргааны хэм хэмжээний акт нь энэ хуулийн 67.1-д заасны дагуу нийтэлснээр хүчин төгөлдөр болно. Захиргааны хэм хэмжээний актад дагаж мөрдөх хугацааг өөрөөр зааж болно.” гэж заасны дагуу зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан боловсруулж буй инженерийн нарийвчилсан зураг төслийн барилгын ажлын төсөвт магадлал хийхдээ 2019 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 256 дугаар тушаалыг мөрдөж ажиллана уу.

Хавсралт 3... хуудастай.

АВТО ЗАМЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.СУГАРМАА



030002909



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33.

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.04.18 № 1/1922

танай 2024.09.19-ны № 03/1135 -Т

### ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД С.БЯМБАЦОГТ ТАНАА

“Нормд өөрчлөлт оруулах тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/63 дугаар тушаалыг үндэслэн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 4457 дугаарт бүртгэлтэй “Норм батлах тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 256 дугаар тушаалын 1 дэх хавсралтад оруулсан өөрчлөлтийг хүлээн авч холбогдох хөдөлгөөн хийснийг үүгээр мэдэгдье.



Б.ЭНХБАЯР

151601370

Засгийн газрын хэм хэмжээний  
Автын улсын нэгдсэн санд  
2024 оны 03 сарын 19-ны  
өдөр хүлээн авсан.



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2024 оны 03 сарын 19 өдөр

Луган 47/65

Улаанбаатар хот

Нормд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" 120 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн "Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, амин дэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ батлах тухай" А/74 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 256 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм" ЗЗБНБД 81-013-2019-ын заалтуудад дараах өөрчлөлтийг оруулсугай.

а/Нормын 4.5.1-д "Хот болон төв суурин газар, хөдөө орон нутагт ажиллах замчин, машин механизмын операторчин, жолооч, тээвэрчдэд ажилласан өдөр тутамд 9800 төгрөгийн "Авто замын барилга, засвар, арчлалтын ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал"-ыг олгохоор тооцож төсөвт тусгана." гэснийг "Хот болон төв суурин газар, хөдөө орон нутагт ажиллах замчин, машин механизмын операторчин, жолооч, тээвэрчдэд ажилласан өдөр тутамд 14000 төгрөгийн "Авто замын барилга, засвар, арчлалтын ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал"-ыг олгохоор тооцож төсөвт тусгана."

б/Нормын 4.5.2-д "Төсөвт тусгах "Авто замын барилга, засвар, арчлалтын ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал"-ын хэмжээг үндсэн ажлын нийт хөдөлмөр зарцуулалт (хүн.цаг), машин механизм, тоног төхөөрөмжийн нийт машин цагийн тоо (маш.цаг), тээврийн зардал, нүүлгэн шилжүүлэх зардалд тооцогддог тээврийн нийт хөдөлмөр зарцуулалтын (хүн.цаг) нийлбэрийг ажлын нэг өдрийн үргэлжлэх хугацаа (7.97)-д хувааж ногдворыг нэг хүн.өдрийн ажилтнуудад үйлчлэх зардал болох 9800 төгрөгөөр үржүүлж гаргана." гэснийг "Төсөвт тусгах "Авто замын барилга, засвар, арчлалтын ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал"-ын хэмжээг үндсэн ажлын нийт хөдөлмөр зарцуулалт (хүн.цаг), машин механизм, тоног төхөөрөмжийн нийт машин цагийн тоо (маш.цаг), тээврийн зардал, нүүлгэн шилжүүлэх зардалд тооцогддог тээврийн нийт хөдөлмөр зарцуулалтын (хүн.цаг) нийлбэрийг ажлын нэг өдрийн үргэлжлэх хугацаа (7.97)-д хувааж ногдворыг нэг хүн.өдрийн ажилтнуудад үйлчлэх зардал болох 14000 төгрөгөөр үржүүлж гаргана."

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ  
ХУУЛБАР ҮНЭН  
Хуулбар өлгөсөн амжилтын гарын үсэг  
Дуушаа  
2024 оны 03 сарын 19-ний өдөр



2. "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм" ЗЗБНБД 81-013-2019-д оруулсан өөрчлөлтийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Авто замын бодлого зохицуулалтын газар (Ч.Сугармаа), Хуулийн хэлтэс (С.Мяндасмаа), Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Цэвэлмаа), "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ (Х.Пүрэвжаргал), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (А.Мөнхбат)-т тус тус даалгасугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ

